



RioTinto

Бидний
ажлын арга
барил



Гарчиг

4	Оршил
6	Бидний үнэт зүйлс
7	Санаа тавих
8	Зоригтой байх
9	Сониуч байх
10	Манай ёс зүйн дүрэм
12	Аюулгүй ажиллагаа ба эрүүл мэнд
13	Хөдөлмөрийн харилцаа ба оролцоо
14	Хүний эрх
15	Мэдээллийн нууцлал
16	Ашиг сонирхлын зөрчил
17	Шударга өрсөлдөөн
18	Хээл хахууль, авлига
19	Нууц мэдээлэл ба дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох
20	Орон нутгийн иргэд
21	Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм
22	Ил тод харилцаа холбоо
23	Байгаль орчин
24	Оюуны өмч
25	Компанийн өмч ба бүртгэл
27	Зөв сонголт хийх

Оршил

Бидний ажлын арга барил хэмээх энэхүү баримт бичиг нь бидэнд зорилго, бодлогоо хэрхэн хэрэгжүүлэхийг, тэр дундаа бидний үнэт зүйлс болох санаа тавих, зоригтой байх, сониуч байхыг хэрхэн баримталж ажиллахыг тодорхой зааж өгдөг.



Бидний үнэт зүйлс

Бидний үнэт зүйлс энгийн, хүнлэг, мөн бидэнд хамгийн чухал зүйлсийг агуулсан.

Бид үнэт зүйлсээ шинэчлэхдээ бидний ирээдүйд амин чухал байх зүйлсийг тусган, баяжуулсан. Бид бүгд илүү ихээр харахыг хүсэж буй эерэг зан үйлдээ анхаарлаа төвлөрүүлснээр үнэт зүйлсээ бодит болгож чадна.

Тэдгээр үнэт зүйлс нь:

Хамтран зүтгэгчид, хүрээлэн буй нийгэм, байгаль орчиндоо **санаа тавих**

Шинэ зүйлсийг турших, дуу хоолойгоо хүргэх, зөв зүйтэй бүхнийг хийх **зоригтой байх**

Хамтран зүтгэх, шинэ, шинэлэг бүхнийг суралцах, турших, шинийг санаачлах хүсэл тэмүүлэлтэй **сониуч байх** юм.



санаа тавих

Бид эргэн тойрныхоо хүмүүсийн бие, сэтгэлийн аюулгүй байдал, сайн сайханд нэн тэргүүнд **санаа тавьж** ажиллана. Бид бусдыг хүндэтгэж, итгэлцэл бүхий харилцааг бэхжүүлж, өөрсдийн үйл ажиллагааны үр нөлөөг анхаарч, ажилтнууддаа, үйл ажиллагаа явуулж буй улсдаа, эх дэлхийдээ илүү сайхан ирээдүйг авчрахад хувь нэмрээ оруулах арга замыг тасралтгүй эрэлхийлдэг.



зоригтой байх

Бид **зоригтой байж**, ёс зүйгээр үлгэрлэж, буруу зүйлийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй төдийгүй шаардлагатай бол шийдэмгий арга хэмжээ авна. Бид шинэ зүйл туршиж үзэхээс айхгүй. Бид хүнд нөхцөлд ч эерэг хандлагаа хадгалж, нийтлэг зорилгынхоо төлөө зогсолтгүй урагшилна.

сониуч байх

Бид **сониуч байж**, олон талт үзэл бодлыг хөхиүлэн дэмжиж, ганц нэгээрээ бус олуулаа хамтран ажиллаж илүү ихийг бүтээнэ. Бид тасралтгүй суралцаж, аливаа ажлыг улам сайн, аюулгүй хийх арга замыг бүтээлчээр эрэлхийлнэ. Бид бусдаас, эргэн тойрноосоо урам зориг авна.





Манай ёс зүйн дүрэм

Бид хаана ажиллаж буй эсвэл хаанаас ирснээсээ үл хамааран, зөв сонголт хийхийн тулд өөртөө болон бусдадаа хяналт тавих, хариуцлагатай хандах тодорхой хэм хэмжээг баримтална.

Аюулгүй ажиллагаа ба эрүүл мэнд

- Бид дор бүрнээ аюулгүй ажиллаж, холбогдох стандартыг сахин мөрдөж, орчин тойрныхоо хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд анхаарч ажиллах үүрэгтэй.
- Бид бүгд өдөр бүр ажлын бүрэн чадвартай байх үүрэгтэй. Энэ нь Рио Тинтод ажил үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах ундаа эсвэл мансууруулах бодисын нөлөөнөөс ангид, сайн амарсан, ажил үүргээ гүйцэтгэх биеийн болон оюуны чадвартай байна гэсэн үг.
- Бид хамтран ажилладаг зөвлөх, төлөөлөгч, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч болон бусад этгээдүүдээс манай эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагыг хүндэтгэж, сахин мөрдөхийг хүсэн хүлээдэг.
- Хамт олон маань ажлаа гүйцэтгэх явцдаа өөрсдийн эсвэл бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна гэж үзвэл бид ажлыг нь зогсоож, энэ талаар мэдээлэх үүрэгтэй.

Бид бүх осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх бүрэн боломжтой гэдэгт итгэдэг. Хүн бүхэн өдөр бүр гэртээ эсэн мэнд, эрүүл саруул харих ёстой гэсэн зорилгыг бид мөрдлөг болгон ажилладаг.



Хөдөлмөрийн харилцаа ба оролцоо

- Бид ялгаатай байдлыг үнэлж, арьсны өнгө, хүйс, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, нас, бэлгийн чиг хандлагаас нь үл хамааран бүх ажилтан, түншүүдээ эн тэнцүү хүндэтгэж харьцдаг.
- Бид хүний нэр төрийг нь эрхэмлэж, хүндэтгэлтэй хандах ёстой гэж үздэг. Манай ажлын байранд ямар нэгэн хэлбэрээр дээрэлхэх, айлган сүрдүүлэх, дарамтлах явдлыг тэвчихгүй.
- Бид хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тухайн улс орны хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийг сахин биелүүлэх үүрэг амлалт авсан. Бид үйлдвэрчний эвлэлд нэгдэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хүлээн зөвшөөрдөг.
- Бид хөгжиж буй улс орнуудаас олборлосон эрдэс баялгийн эдийн засгийн үр ашгийг орон нутгийн ард иргэдтэй хуваалцахын тулд тухайн улс орны засгийн газруудтай хамтран ажилладаг. Үүнд орон нутгийн ажил эрхлэлт, боломжтой бол орон нутгийн худалдан авалтыг дэмжих ажил орно.

Бид манай бүх ажилтан шударга бөгөөд өөрсдийнх нь оролцоог хангасан орчинд ажиллаж, түүгээрээ бахархах эрхтэй гэж үздэг.



Хүний эрх

- Бид НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэмжиж, үйл ажиллагаа явуулж буй газар бүртээ эдгээр эрхийг хүндэтгэн ажилладаг. Бид НҮБ-ын бизнес ба хүний эрхийн талаар баримтлах зарчмуудад нийцсэн үйл ажиллагаа явуулах үүрэг амлалт авсан. Өөрөөр хэлбэл бид шууд болон дам байдлаар хүний эрхэд ямар сөрөг нөлөөлөл учруулж байгаагаа олж тогтоох, тэдгээр нөлөөллийг зохицуулах шаардлагатай гэсэн үг.
- Бид ханган нийлүүлэгчдээсээ ч мөн адил хүний эрхийн стандартыг сахин мөрдөхийг хүсдэг. Бид хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг, албадмал хөдөлмөрийн аливаа хэлбэрээс татгалздаг. Бид өөрсдийн бизнесийг хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөрийн аливаа хэлбэрээс ангид байлгаж, хангамжийн сүлжээгээ олон улсын стандартад нийцүүлэхийн тулд шаргуу ажилладаг.
- Бид аюулгүй байдлаа хангахдаа хүний эрхийг зөрчихөөс сэргийлэхийн тулд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч хувийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Бид ажлын талбайнхаа аюулгүй байдлыг хангахдаа галт зэвсэг хэрэглэхийг аль болох хязгаарладаг.

Бид хүний эрхийг хүндэтгэж, хүний эрхийг зөрчихгүй байхыг зорьдог.



Мэдээллийн нууцлал

- Бид зөвхөн хууль ёсны бизнесийн зорилгод шаардлагатай болсон тохиолдолд л хамт олон, оролцогч талууд, бизнесийн түншүүд, ханган нийлүүлэгчид, худалдан авагчид болон тэдний гэр бүл, ойрын төрөл садны хувийн мэдээллийг цуглуулж, тэдгээр мэдээлэлтэй харьцдаг. Бид өөрсдийнхөө мэдээллийг хянаж, шинэчилж, залруулах хүн бүрийн эрхийг хүндэтгэдэг.
- Зөвхөн хууль ёсны бизнесийн хэрэгцээ гарсан эсхүл хуулийн дагуу шаардсан тохиолдолд л хувийн мэдээллийг бусадтай хуваалцана. Ингэхдээ хувийн мэдээлэл хүлээн авч буй этгээд тухайн мэдээллийг нууцлах ач холбогдлыг ойлгож байгаа эсэхэд анхаарна.
- Бид манай мэдээлэлтэй танилцах буюу боловсруулах аливаа этгээдтэй хамтран ажиллахдаа мэдээллийн нууцлалд тавигдах шаардлагууд болон тэднээс хүсэн хүлээж буй хэм хэмжээг тодорхой болгож өгдөг.

Бид хүний хувийн нууцыг хүндэтгэдэг. Бид бизнесийн үйл ажиллагааны хүрээнд хувийн мэдээлэл цуглуулж, ашиглаж, хамгаалахдаа бүх хууль тогтоомжийг сахин биелүүлдэг.



Ашиг сонирхлын зөрчил

- Бид ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй мэт харагдахаас зайлсхийхийн тулд ул суурьтай ханддаг.
- Бид ашиг сонирхлын бодит болон болзошгүй зөрчлийг урьдчилан мэдүүлдэг. Зөрчлөөс зайлсхийх боломжгүй үед бусадтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр ил тод, зохистой хэлбэрээр зохицуулна.
- Бид Рио Тинтод хашиж буй албан тушаал, ажил үүргээ ашиглан далдуур өөртөө давуу байдал бий болгохыг зөвшөөрөхгүй.

Шударга өрсөлдөөн

- Бид чөлөөт, шударга өрсөлдөөнд итгэдэг. Бид олон улсын хэмжээнд ёс зүйтэй өрсөлдөж, өрсөлдөөний тухай, монополийн эсрэг холбогдох бүх хууль тогтоомжийг хүндэтгэдэг.
- Бид өрсөлдөгчид, ханган нийлүүлэгчид, худалдан авагчдынхаа мэдээллийг хууль бусаар олж авдаггүй, өрсөлдөгчдийнхөө талаар худал мэдээлэл түгээдэггүй.
- Бид өрсөлдөгчидтэйгөө, эсвэл өрсөлдөж болзошгүй байгууллагатай харилцахдаа бидний өрсөлдөөнд нөлөөлж болох нууцлалтай мэдээллийг тэдэнд өгдөггүй.

Бидний хувийн ажил төрөл, ашиг сонирхол, холбоо харилцаа Рио Тинтогийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай маань зөрчилдөхгүй байхад анхаарч ажилладаг.



Бид бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйн зарчмуудыг баримталж, хууль ёсны дагуу өрсөлддөг.



Хээл хахууль, авлига

- Бид хаана үйл ажиллагаа явуулж байгаа, нөхцөл байдал ямар байгаа, хэн оролцож байгаагаас үл хамааран хээл хахууль санал болгодоггүй, өгдөггүй. Үүнийг бид төлөөлөгч, зуучлагчдадаа ч зөвшөөрдөггүй. Хээл хахууль нь хийх ёсгүй зүйл, зохисгүй үйлдэл хийлгэх, эсвэл хийвэл зохих зүйлийг нь хийлгэхгүй байхын тулд бэлэг, төлбөр, давуу тал өгч хэн нэгнийг ятгахыг хэлнэ. Түүнчлэн, хэн нэгэн хийх ёстой зүйлээ хийхдээ бага гэлтгүй төлбөр нэхэхийг хэлнэ.
- Бид хэзээ ч хээл хахууль өгч, авдаггүй. Бид ажлаа хийхдээ бусдаас санхүүгийн, өөр бусад давуу тал шаарддаггүй, өгдөггүй. Мөн ийм давуу тал, урамшууллын нөлөө ятгалгад орж зүй бүс үйлдэл гаргадаггүй, Рио Тинтогийн өмнө хүлээсэн үүргээ зөрчдөггүй.

Нууц мэдээлэл ба дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох

- Нууц мэдээлэл гэдэгт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцын талаарх техникийн мэдээлэл, ханган нийлүүлэгчийн жагсаалт, үнэ, маркетингийн, үйлчилгээний стратеги, олон нийтэд мэдээлээгүй санхүүгийн тайлан, хөрөнгө худалдсан, нэгтгэсэн, худалдаж авсан тухай мэдээлэл орно.
- Бид нууц мэдээллийн талаар хаана, хэнтэй ярихаа, хаана, хэрхэн хадгалахаа сайн бодож, хянамгай хандах ёстой.
- Бид хувийн ашиг хөөх, давуу байдал олохын тулд ямарваа нууц мэдээллийг ашигладаггүй, задруулдаггүй.
- Бид компанийн дотоод мэдээллийг бусад хүмүүстэй, тэр дундаа гэр бүл, найз нөхөдтэйгөө хуваалцдаггүй. Бид дотоод мэдээллийг ашиглан Рио Тинтогийн, гуравдагч этгээдийн үнэт цаасны арилжаанд оролцох зөрчил хэзээ ч гаргаж болохгүй.

Бид аливаа хэлбэрийн хээл хахууль, авлигын хэрэгт холбогддоггүй.



Бид өөрсдийнхөө болон гуравдагч этгээдийн нууц мэдээллийг хариуцлагатайгаар хянан удирдсанаар хувьцаа эзэмшигчдийг, мөн өөрсдийгөө хамгаалдаг. Бид ийм мэдээллийг хэзээ ч хувьдаа ашиглаж болохгүй.



Орон нутгийн иргэд

- Орон нутгийн, бүс нутгийн ард иргэдтэй тогтоосон бидний харилцаа холбоо манай төслийн, үйл ажиллагааны нэн чухал хэсэг юм. Бид хөршүүдийнхээ соёл, амьдралын хэв маяг, өв уламжлалыг ойлгож, хүндэтгэдэг.
- Бид орон нутгийн, уугуул иргэдийн газар шороо, уул устайгаа тогтоосон онцгой харилцаа, шүтэлцээг хүндэтгэдэг. Бид үйл ажиллагаагаа боловсруулж, хэрэгжүүлэхдээ тухайн орон нутгийн иргэдийг татан оролцуулж, харилцан ашигтай байхыг эрмэлздэг.
- Бид НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалд нэгдсэн улс орнуудад үйл ажиллагаагаа явуулахдаа тус тунхаглалыг мөрдөж ажиллах бөгөөд бусад улс оронд ч гэсэн тунхаглалын зарчмыг баримтлан ажиллана. Бид 2012 оны Олон улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн стандарт 7, дагалдах зөвлөмж, мөн хууль тогтоомжид заасны дагуу уугуул иргэдийг мэдээллээр хангаж, шийдвэрийг нь чөлөөтэй гаргуулж, зөвшөөрлийг нь урьдчилж авахад зорьж ажилладаг.
- Бидний үйл ажиллагаанаас учруулж болох аливаа нөлөөллийг орон нутгийн иргэдэд ойлгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тусгасан, орон нутаг, бүс нутгийн хөгжилд анхаарсан тогтвортой хөгжлийн зохих санаачилгуудыг хэрэгжүүлэхдээ бид орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудтай хамтран ажилладаг.

Бид орон нутгийн, бүс нутгийн иргэдтэй хүндэтгэл, нээлттэй харилцаа, нийтлэг ашиг сонирхол дээр үндэслэсэн бат бөх, удаан хугацааны харилцаа тогтоосноор тэднээс байнгын дэмжлэг авч байхыг эрмэлздэг.



Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм

- Бид улс орон бүр дэх улс төрийн үйл ажиллагааг хүндэтгэж, аль нэг улс төрийн нам, бүлгийг, аль нэг улс төрчийг дэмждэггүй. Компанийн хувьд бид намын улс төрийн асуудалд оролцдоггүйн дээр улс төрийн нам, нэр дэвшигчдэд аливаа хэлбэрээр төлбөр төлдөггүй.
- Бид хувь хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаггүй. Үндсэн, гэрээт ажилтнууд чөлөөт цагаараа, өөрсдийнхөө мөнгөөр улс төрийн нам, нэр дэвшигч, кампанит ажлыг дэмжиж болно.
- Манай бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх төрийн бодлого, хууль эрх зүйн асуудалд бид оролцдог. Бид хүчтэй бодлого, хууль тогтоомж, дүрэм журам гаргахад туслахаар холбогдох мэдээлэл өгч, туршлагаасаа хуваалцдаг.

Бид засгийн газартай урт хугацааны харилцаа тогтоож, олон улсын байгууллага, иргэний нийгмийг хүндэтгэж, хамтран ажилладаг.



Ил тод харилцаа холбоо

- Бид үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийнхээ талаар үнэн зөв мэдээллийг оролцогч талуудтай, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллага, хөрөнгө оруулагчид, зохицуулах байгууллагуудтай хуваалцдаг.
- Бид мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, салбартаа Рио Тинто хэрхэн дүгнүүлэхэд нөлөөлж болох томоохон мэдээллийг хуваалцана.
- Бид шударга, нээлттэй харилцаа холбоо тогтоож, мэдээлэл, ойлголт, зөвлөмжөө тогтмол, бүтээлчээр хуваалцаж, хүнд хэцүү нөхцөл байдлыг зоригтойгоор хянан зохицуулдаг.

Бид нээлттэй, шударгаар харилцаж, итгэлцлийг бэхжүүлдэг.



Байгаль орчин

- Бид үйл ажиллагаагаа төлөвлөж, уурхай байгуулж, ажиллуулж, ашиглалтаас гаргаж хаахдаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээс маань байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг ойлгож, бууруулдаг.
- Бид нөөц баялагт, зах зээлд тасралтгүй нэвтрэх боломжийг бүрдүүлэхийн тулд бүтээгдэхүүний ашиглалтын мөчлөг, биологийн олон янз байдал, нүүрстөрөгч, эрчим хүчний зохицуулалт, газар, ус, агаар ашиглалт, уурхайн талбай хаах ажиллагаа зэргийг тууштай сайжруулахыг үргэлж эрэлхийлж, үйл ажиллагаа явуулж буй газар нутгийнхаа орон нутгийн иргэдтэй хамтран ажилладаг.


Бид үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийнхаа байгаль орчны үнэт зүйлсийг хамгаалж, урт хугацаанд хайрлан хамгаалсаар байхад зорьж ажилладаг.



Оюуны өмч

- Бид оюуны өмчөө (патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг, худалдааны нууц зэрэг) хамгаалж, бусад этгээд зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй эсэхийг сайтар хянадаг.
- Манай ханган нийлүүлэгч, худалдан авагч, өрсөлдөгч зэрэг бусдын оюуны өмчийг бид хүндэтгэж, зөвшөөрлийг нь авсны үндсэн дээр л оюуны өмчийг нь ашигладаг.

Оюуны өмчөө хамгаалж, бусдын оюуны өмчийг хүндэтгэснээр өрсөлдөх чадвараа хадгалдаг.



Компанийн өмч ба бүртгэл

- Бид компанийн өмч хөрөнгө, санхүүгийн нөөцийг хувийн (үүний дотор гэр бүлийн) хэрэгцээ, ашиг тусын тулд, эсвэл ашиг сонирхлын зөрчил үүсгэх, эсвэл зохисгүй, хууль бус үйл ажиллагаанд ашиглах зорилгоор авах, ашиглах, зориулалтыг нь өөрчилж болохгүй.
- Ажлаа хийхэд маань бидэнд тус дэм болгож цахим шуудан, интернет, утас зэрэг электрон хэрэгслээр хангаж ашиглуулдаг. Хэрвээ компанийн системд нөлөөлөхгүй, компанид зүй бус зардал учруулахгүй, ажил үүргээ явуулахад маань саад болохгүй бол эдгээр хэрэгслийг хувийн зорилгодоо хааяа ашиглаж болно.
- Бид Группийн баримт бичиг хадгалах бодлого, журмын дагуу компанийн санхүүгийн, санхүүгийн бус бүх баримт материалын бүртгэлийг үнэн зөв хөтөлдөг.
- Бидэнд зөвшөөрөл өгөөгүй бол компанийн өмч хөрөнгө, компанийн бүртгэлд өөрчлөлт, хасалт хийхийг, устгахыг хориглодог.

Бид компанийн өмч хөрөнгө, санхүүгийн, цахим хэрэгслийг хувьдаа, зөвшөөрөлгүйгээр ашигладаггүй, гагцхүү компанийн бизнесийн үйл ажиллагаанд ашигладаг.





Зөв сонголт хийх

Бидний ажлын арга барил нь ямарваа сонголт хийхийн өмнө нөхцөл байдлыг тунгаан ойлгох, үнэлэхэд тус дэм болохуйц тодорхой хил хязгаарыг зааж өгдөг юм. Тус баримт бичиг нь зарим хэцүү нөхцөл байдалд ямар үйлдэл хийхээ тодорхойлоход бидэнд тусалдаг билээ.

Сонголтын өмнө ирсэн бол өөртөө дараах асуултыг тавь:

- Миний үйлдэл *Бидний ажлын арга барил* болон Рио Тинтогийн бодлого, стандартад нийцэх үү?
- Би найз нөхдөдөө, гэр бүлийнхэндээ юу хийхийг зөвлөх байсан вэ?
- Миний үйлдлийн талаар бусад хүн юу гэж бодох вэ?
- Сонины нүүрэн дээр энэ тухай гарвал яаж харагдах вэ?

Хэрвээ танд эдгээр асуултын аль нэгэнд хариулахад хэцүү байвал ямарваа үйлдэл хийхээсээ өмнө зөвлөгөө авах нь зүйтэй.

Тухайн улсын хууль тогтоомж ба Бидний ажлын арга барил

Ажиллаж буй улс орон бүртээ бид холбогдох хууль тогтоомжийг нь сахин мөрддөг. Та тухайн улсын хууль тогтоомж болоод Бидний ажлын арга барилын зарчмын алийг нь мөрдөхийг

шийдэх бол, илүү хатуу шаардлага тогтоосныг нь баримтална. Хэрвээ тухайн улсын хууль тогтоомж, *Бидний ажлын арга барил*, эсвэл манай аль нэг бодлого, стандартыг зөрчвөл танд сахилгын арга хэмжээ хүлээлгэнэ. Ингэхдээ ажлаас халах, таны гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

Хэрвээ та тухайн улсын хууль тогтоомж, *Бидний ажлын арга барил*, манай аль нэг бодлого, стандартыг зөрчиж магадгүй ямар нэгэн зүйлийг харвал үл ойшоож орхилгүй, харин мэдээлэх ёстой.

Удирдах ажилтан, хамт ажилладаг хүндээ эсвэл Хүний нөөц, Ёс зүй дүрмийн хэрэгжилт, Хуулийн хэлтсийн ажилтан зэрэг өөрийн итгэж болох хүндээ хандаарай. Мөн та санаа зовнисон асуудлаа Рио Тинтогийн мэдээллийн нууцыг чандлан хадгалдаг, аюулгүй myVoice хөтөлбөрөөр дамжуулан мэдээлж болно. myVoice хөтөлбөрийг шударгаар ашигласан аливаа ажилтнаас ямарваа байдлаар өшөө авах үйлдлийг тэвчихгүй.

Үлгэрлэн манлайлах –*Бидний ажлын арга барилыг* ойлгож хэрэгжүүлэхэд нь бусдад тусал.

RioTinto

Rio Tinto Limited
120 Collins Street
Melbourne, Victoria 3000
Australia

T +61 (0)3 9283 3333

Rio Tinto plc Head Office
6 St James's Square
London, SW1Y 4AD
United Kingdom

T +44 (0)20 7781 2000

Рио Тинтогийн бодлого, стандарт

Бидний ажлын арга барилыг дэмжих олон бодлого, стандарт бий. Зөв сонголт хийхэд тань тус дэм болох эдгээр бодлого, стандарттай танилцахыг та бүхэнд зөвлөж байна. Бидний ажлын арга барил, холбогдох бодлого, стандартад тусгасан агуулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <http://bit.ly/2rgWxiG> хаягаар орж авна уу.

Рио Тинтотой хамтарч, мөн Рио Тинтод ажиллахдаа таны хэрэгжүүлэх тодорхой, энгийн зарчмыг Бидний ажлын арга барилд нэгтгэн оруулсан бий. Таны хэн болох, ямар зарчим баримталдгийг тань таны үйлдэл олон түмэнд харуулдаг.